

**“МОНГОЛ УЛСЫН ХӨГЖЛИЙН 2026 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ БАТЛАХ ТУХАЙ”
МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛЫН ТӨСЛИЙН ХОЁР ДАХЬ
ХЭЛЭЛЦҮҮЛГИЙГ ЯВУУЛСАН ТАЛААРХ НИЙГМИЙН БОДЛОГЫН
БАЙНГЫН ХОРООНЫ САНАЛ, ДҮГНЭЛТ**

2025 оны 05 дугаар
сарын 20-ны өдөр

Улаанбаатар
хот

Илтгэгч нь: Улсын Их Хурлын гишүүн Б.Бат-Эрдэнэ

Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2025 оны 04 дүгээр сарын 30-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн “Монгол Улсын хөгжлийн 2026 оны төлөвлөгөө батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн нэг дэх хэлэлцүүлгийг Улсын Их Хурлын чуулганы 2025 оны 05 дугаар сарын 15-ны өдрийн нэгдсэн хуралдаанаар хэлэлцэн шийдвэрлэж, төслийг хоёр дахь хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Байнгын хороодод шилжүүлсэн билээ.

Нийгмийн бодлогын байнгын хороо 2025 оны 05 дугаар сарын 20-ны өдрийн хуралдаанаараа дээрх тогтоолын төслийн хоёр дахь хэлэлцүүлгийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 66 дугаар зүйлд заасныг баримтлан явуулж, дараах санал, дүгнэлтийг гарган Та бүхэнд танилцуулж байна.

Байнгын хорооны хуралдаанаар тогтоолын төслийн хоёр дахь хэлэлцүүлгийг явуулах үед Улсын Их Хурлын гишүүн С.Эрдэнэбат эрүүл мэндийн салбарын хүний нөөцийн цалин, хөлсийг нэмэгдүүлэх, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлагыг хангаж ажиллах, осол, гэмтлээс урьдчилан сэргийлэх арга, хэмжээнүүд болон банкны зээлийн хүүг бууруулах асуудлууд хөгжлийн төлөвлөгөөнд хэрхэн туссан талаар, Улсын Их Хурлын гишүүн Ж.Чинбүрэн эрүүл мэндийн салбарын санхүүжилтийг нэмэгдүүлэх, хүнс, эмийн лавлагаа лабораторийг нэгтгэх асуудлууд хөгжлийн төлөвлөгөөнд тусгагдсан эсэх, Улсын Их Хурлын гишүүн Ц.Идэрбат 2026 онд нүүрсний үнийн өсөлтийг хэрхэн харж байгаа талаар, “Миний түрээсийн орон сууц”, “Миний амины орон сууц” хөтөлбөрүүд орон нутагт хэрхэн хэрэгжих талаар, тэтгэвэр барьцаалсан зээлийн хугацааны талаар, хүүхэд хамгаалал, хөгжлийн төсвийн талаар, Улсын Их Хурлын гишүүн Б.Бат-Эрдэнэ хөгжлийн төлөвлөгөөнд тусгагдсан 150 мянган айлын орон сууцыг барих санхүүжилт, түүний тооцооллын талаар, хүүхэд, өсвөр үеийнхний сэтгэл зүйн тулгамдсан асуудлыг шийдвэрлэх арга, хэмжээнүүд хөгжлийн төлөвлөгөөнд тусгагдсан эсэх талаар, Улсын Их Хурлын гишүүн М.Нарантуяа 2025 оны хүүхэд хамгааллын төсөв хүүхдийн хөгжил, хамгаалалд хэрхэн зарцуулагдаж байгаа талаар, Хүүхдийн төлөө үндэсний зөвлөлөөс хүүхэд хамгааллаас илүүтэй хүүхэд хөгжлийн чиглэлээр хөтөлбөр, арга хэмжээнүүд хэрэгжүүлэхээр шийдвэрлэсэн байгаа шалтгааны талаар, эрт илрүүлгийн хүрээнд умайн хүзүүний хорт хавдрын эрт илрүүлэг хийгдэж байгаа эсэх талаар, Улсын Их Хурлын гишүүн Ж.Баярмаа Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний талаарх хөтөлбөрүүдийн хэрэгжилтийн талаар тус тус асуулт, асууж хариулт авлаа.

Улсын Их Хурлын гишүүдийн зүгээс тогтоолын төсөлтэй холбогдуулан гаргах зарчмын зөрүүтэй саналаа Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.14 дэх хэсгийг баримтлан бичгээр, урьдчилан ирүүлсэн бөгөөд Байнгын хороо зарчмын зөрүүтэй 19 саналын томьёоллоор нэг бүрчлэн санал хураалт явууллаа.

“Монгол Улсын хөгжлийн 2026 оны төлөвлөгөө батлах тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс ирүүлсэн зарчмын зөрүүтэй саналын томьёоллуудыг Нийгмийн бодлогын байнгын хороогоор хэлэлцээд дэмжсэн, дэмжээгүйгээр нь бүлэглэн Та бүхэнд хүргүүлсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

“Монгол Улсын хөгжлийн 2026 оны төлөвлөгөө батлах тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийн хоёр дахь хэлэлцүүлгийг явуулсан талаарх Нийгмийн бодлогын байнгын хорооны санал, дүгнэлт, зарчмын зөрүүтэй саналын томьёоллуудыг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг Та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

**НИЙГМИЙН БОДЛОГЫН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА**



Л.ЭНХНАСАН

**“МОНГОЛ УЛСЫН ХӨГЖЛИЙН 2026 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ БАТЛАХ ТУХАЙ”
МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛЫН ТӨСЛИЙН ТАЛААРХ ЗАРЧМЫН
ЗӨРҮҮТЭЙ САНАЛЫН ТОМЬЁОЛОЛ**

Нэг. Нийгмийн бодлогын байнгын хорооны дэмжигдсэн санал

1.Төслийн 1 дүгээр хавсралтын 2.3.3 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“2.3.3.Хүүхэд хамгааллын кейс менежмент, нийгмийн ажлын мэргэжлийн удирдлагыг хөгжүүлж, төрийн бүх албан хаагчдыг хүүхэд хамгааллын болон хүний эрхийн цахим сургалтад хамруулж, хүүхэд хамгааллын үйлчилгээг хүүхэд бүрд хүргэнэ.”

Санал гаргасан: Улсын Их Хурлын гишүүн Ж.Баярмаа

2.Төслийн 1 дүгээр хавсралтын 2.2.1 дэх заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“Хүн амд зонхилон тохиолдож байгаа зүрх судас, хавдрын өвчлөлийг эмчилгээний шинэ технологи, туршлагыг нэвтрүүлэх замаар бууруулах цогц бодлогыг хэрэгжүүлнэ.”

Санал гаргасан: Улсын Их Хурлын гишүүн Д.Ганмаа

3.Төслийн 1 дүгээр хавсралтын 2.2.2 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“2.2.2.Гарцад суурилсан санхүүжилтийн шинэчлэлийг бэхжүүлэх хүрээнд тусламж, үйлчилгээ худалдан авагчийн чанар, төлбөрийн хяналтыг хиймэл оюун ухааныг ашиглаж боловсронгуй болгож, эрүүл мэндийн даатгалын санхүүжилтийн үр ашгийг сангийн актуар тооцоолол дээр суурилан нэмэгдүүлнэ.”

Санал гаргасан: Улсын Их Хурлын гишүүн Д.Ганмаа

4.Төслийн 1 дүгээр хавсралтын 2.2.4 дэх заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“2.2.4.Төр, хувийн хэвшлийн үр ашигтай, үр дүнтэй түншлэлийг бий болгох хүрээнд эрүүл мэндийн салбарын төсөв доторх олон улсын хөтөлбөр, гадаадын зээл тусламжаар оруулсан хөрөнгө оруулалтын үр дүнг шалгуур үзүүлэлтээр үнэлдэг тогтолцоог бүрдүүлж, үр дүнг иргэдэд нээлттэй, ил тод тайлагнана.”

Санал гаргасан: Улсын Их Хурлын гишүүн Д.Ганмаа

5.Төслийн 1 дүгээр хавсралтын 2.2.6 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“2.2.6. Хүн амын амьдралын хэв маяг, зан үйл, орлого, боловсрол, орчин, ахуйн нөхцөл, соёл уламжлал зэрэг нийгэм, эдийн засгийн хүчин зүйлийн харгалзан, эрүүл мэндийн тэгш бус байдлыг арилгахад нөөцийг үр ашигтай хуваарилах замаар нийгмийн эрүүл мэндийн арга хэмжээг оновчтой тодорхойлж үр

дүнг шалгуур үзүүлэлтээр үнэлснээр хүн амын бие бялдрын хөгжлийн түвшнийг нэмэгдүүлнэ.”

Санал гаргасан: Улсын Их Хурлын гишүүн Д.Ганмаа

6.Төслийн 1 дүгээр хавсралтын 2.2 дахь хэсэгт доор дурдсан агуулгатай 2.2.7 дахь заалт нэмэх:

“2.2.7.Эрэгтэйчүүдийн эрүүл мэндийг дэмжих, тэдэнд хүрэх тусламж үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулан, гэнэтийн осол, гадны шалтгаант нас баралтыг бууруулж, дундаж наслалтыг нэмэгдүүлнэ.”

Санал гаргасан: Улсын Их Хурлын гишүүн Л.Энхнасан

7.Төслийн 1 дүгээр хавсралтын 2.2.3 дахь заалтын “бэхжүүлж” гэсний дараа “яаралтай болон түргэн тусламжийн үйлчилгээг сайжруулж,” гэж нэмэх:

Санал гаргасан: Улсын Их Хурлын гишүүн Л.Энхнасан

8.Төслийн 1 дүгээр хавсралтын 1.1 дэх хэсэгт доор дурдсан агуулгатай 1.1.5 дахь заалт нэмэх:

“1.1.5.Бүсийн зөвлөлд нийгмийн түншлэгч байгууллагууд, Үйлдвэрчний эвлэл, ажил олгогч байгууллагын оролцоог хангаж Бүсийн хөдөлмөр, нийгэм эдийн засгийн хэлэлцээр байгуулна.”

Санал гаргасан: Улсын Их Хурлын гишүүн С.Эрдэнэбат

9.Төслийн 1 дүгээр хавсралтын 2.3 дахь хэсэгт доор дурдсан агуулгатай 2.3.7 дахь заалт нэмэх:

“2.3.7.Орчны болон хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн эрсдэлийг нийгмийн түншлэгч Үйлдвэрчний эвлэл, ажил олгогчдын оролцоонд тулгуурлан бууруулна.”

Санал гаргасан: Улсын Их Хурлын гишүүн С.Эрдэнэбат

10.Төслийн 1 дүгээр хавсралтын 2.2 дахь хэсэгт доор дурдсан агуулгатай 2.2.8 дахь заалт нэмэх:

“2.2.8.Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний нэгдсэн тогтолцоо бүрдүүлэх зорилгоор орон нутагт Нийгмийн эрүүл мэндийн төв байгуулна.”

Санал гаргасан: Улсын Их Хурлын гишүүн М.Сарнай

11.Төслийн 2 дугаар хавсралтын 2.1 дэх хэсэгт доор дурдсан агуулгатай 2.1.1.8 дахь төсөл, арга хэмжээ нэмэх:

“Төсөл, арга хэмжээ”-нд “2.1.1.8.Баянзүрх дүүргийн нэгдсэн эмнэлгийн барилга худалдан авах” гэж, “Шалгуур үзүүлэлт”-д “Худалдан авсан барилга” гэж, “Хэмжих нэгж”-д “Хувь” гэж, “Суурь түвшин”-д “0” гэж, “Зорилтот түвшин”-д “100” гэж,

“Нийт санхүүжилтийн дүн”-д “40,000,000.00” гэж, “Тухайн жилд шаардагдах санхүүжилт”-д “10,000,000.00” гэж, “Санхүүжилтийн эх үүсвэрийн ангилал”-д “Орон нутгийн төсөв” гэж, “Үндсэн хариуцагч”-д “Нийслэлийн Засаг даргын тамгын газар” гэж нэмэх.

Санал гаргасан: Улсын Их Хурлын гишүүн Ж.Чинбүрэн

12. Төслийн 2 дугаар хавсралтын 2.1 дэх хэсэгт доор дурдсан агуулгатай 2.1.3.1 дэх төсөл, арга хэмжээ нэмэх:

“Хөтөлбөрийн үр дүн”-д “2.1.3. Элэг бүтэн Монгол хөтөлбөрийг үргэлжлүүлэх” гэж, “Төсөл, арга хэмжээ”-нд “2.1.3.1.Б, Д вирустай иргэдийн эмчилгээг үргэлжлүүлэх” гэж, “Шалгуур үзүүлэлт”-д “Вирусын эсрэг эмчилгээ” гэж, “Хэмжих нэгж”-д “Хувь” гэж, “Суурь түвшин”-д “0” гэж, “Зорилтот түвшин”-д “1” гэж, “Нийт санхүүжилтийн дүн”-д “20,000,000.00” гэж, “Тухайн жилд шаардагдах санхүүжилт”-д “20,000,000.00” гэж, “Санхүүжилтийн эх үүсвэрийн ангилал”-д “Улсын төсөв” гэж, “Үндсэн хариуцагч”-д “Эрүүл мэндийн яам” гэж нэмэх.

Санал гаргасан: Улсын Их Хурлын гишүүн Ж.Чинбүрэн

13. Төслийн 2 дугаар хавсралтын 2.1 дэх хэсэгт доор дурдсан агуулгатай 2.1.4.1 дэх төсөл, арга хэмжээ нэмэх:

“Хөтөлбөрийн үр дүн”-д “2.1.4. Эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд орчин үеийн техник технологийг нэвтрүүлнэ” гэж, “Төсөл, арга хэмжээ”-нд “2.1.4.1. Робот мэс заслыг Монгол Улсад нэвтрүүлэх, тус мэс заслын аргаар хагалгаа хийж эхлэх” гэж, “Шалгуур үзүүлэлт”-д “Хагалгаа хийсэн тоо” гэж, “Хэмжих нэгж”-д “Тоо” гэж, “Суурь түвшин”-д “0” гэж, “Зорилтот түвшин”-д “50” гэж, “Нийт санхүүжилтийн дүн”-д “5,000,000.00” гэж, “Тухайн жилд шаардагдах санхүүжилт”-д “5,000,000.00” гэж, “Санхүүжилтийн эх үүсвэрийн ангилал”-д “Улсын төсөв” гэж, “Үндсэн хариуцагч”-д “Эрүүл мэндийн яам” гэж нэмэх.

Санал гаргасан: Улсын Их Хурлын гишүүн Ж.Чинбүрэн

14. Төслийн 2 дугаар хавсралтын 1.10 дахь хэсэгт доор дурдсан агуулгатай 1.10.1.2 дахь төсөл, арга хэмжээ нэмэх:

“Төсөл, арга хэмжээ”-нд “1.10.1.2. Нэгдсэн эмнэлгийн барилга, 300 ор, Улаанбаатар, Налайх дүүрэг, 2 дугаар хороо” гэж, “Шалгуур үзүүлэлт”-д “Барилгын ажлын гүйцэтгэл” гэж, “Хэмжих нэгж”-д “Хувь” гэж, “Нийт санхүүжилтийн дүн”-д “80,000,000.00” гэж, “Тухайн жилд шаардагдах санхүүжилт”-д “42,000,000.00” гэж, “Санхүүжилтийн эх үүсвэрийн ангилал”-д “Улсын төсөв” гэж, “Үндсэн хариуцагч”-д “Эрүүл мэндийн яам” гэж нэмэх.

Санал гаргасан: Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очир

15. Төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томьёолол дэмжигдсэнтэй холбогдуулан төслийн агуулга, зарчмыг алдагдуулахгүйгээр төслийн бүтэц, нэр томьёо, хэл найруулга, дэс дараалал, зүйл, заалтын дугаарыг нийцүүлж өөрчлөх.

Санал гаргасан: Улсын Их Хурлын гишүүн Л.Энхнасан

Хоёр.Нийгмийн бодлогын байнгын хорооны дэмжээгүй санал

1.Төслийн 1 дүгээр хавсралтын 2.2 дахь хэсэгт доор дурдсан агуулгатай 2.2.7 дахь заалт нэмэх.

“2.2.7.Нийтийн эрүүл мэндийг дэмжих төлөвлөгөө /2026-2036/ батлана”

Санал гаргасан: Улсын Их Хурлын гишүүн Ж.Баярмаа

2.Төслийн 1 дүгээр хавсралтын 2.3 дахь хэсэгт доор дурдсан агуулгатай 2.3.7 дахь заалт нэмэх:

“2.3.7.Гэр бүлийн цогц хөгжлийг дэмжих төвийг байгуулна.”

Санал гаргасан: Улсын Их Хурлын гишүүн Л.Энхнасан

3.Төслийн 1 дүгээр хавсралтын 2.1 дэх хэсэгт доор дурдсан агуулгатай 2.1.14 дэх заалт нэмэх:

“2.1.14.Багш, ажилчдын цалин хөлс, нийгмийн хамгааллын асуудлыг тэргүүн ээлжинд сайжруулна.”

Санал гаргасан: Улсын Их Хурлын гишүүн С.Эрдэнэбат

4.Төслийн 1 дүгээр хавсралтын 2.3 дахь хэсэгт доор дурдсан агуулгатай 2.3.8 дахь заалт нэмэх:

“2.3.8.Эмч, эмнэлгийн ажилтны цалин хөлсийг жил бүр нэмэгдүүлэх”

Санал гаргасан: Улсын Их Хурлын гишүүн С.Эрдэнэбат

---o0o---

**“Монгол Улсын хөгжлийн 2026 оны төлөвлөгөө батлах тухай”
Улсын Их Хурлын тогтоолын төсөлтэй холбогдуулан гаргасан
зарчмын зөрүүтэй саналын томьёоллын хуудас**

1. Саналыг төслийн ямар зүйл, хэсэг, заалтын талаар гаргаж байгаа:

1.1. Бүсчилсэн хөгжлийн бодлого, эрх зүйн орчин, тогтолцоог боловсронгуй болгоход / заалт нэмэх/

2. Санал хураалгах болсон үндэслэл:

Бүсчилсэн хөгжлийн бодлого, эрх зүйн орчин, тогтолцоог боловсронгуй болгоход “Бүсийн зөвлөлд нийгмийн түншлэгч байгууллагууд, Үйлдвэрчний эвлэл, ажил олгогч байгууллагын оролцоог хангах.

Ингэснээр илүү оновчтой шийдвэрүүдийг хэрэгжүүлэхэд дөхөм болно.

(Тайлбар: Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.4 дэх заалт, 39 дүгээр зүйлийн 39.18 дахь хэсэгт заасны дагуу үндэслэлээ бичээгүй бол уг зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалгахгүй)

3. САНАЛЫН ТОМЬЁОЛОЛ:

1.1.5. Бүсийн зөвлөлд нийгмийн түншлэгч байгууллагууд, Үйлдвэрчний эвлэл, ажил олгогч байгууллагын оролцоог хангаж Бүсийн хөдөлмөр, нийгэм эдийн засгийн хэлэлцээр байгуулна.

Гарын үсэг: (санал гаргасан УИХ-ын гишүүн, нам, эвслийн бүлэг)

УИХ-ын гишүүн С.Эрдэнэбат

Саналыг хүлээж авсан сар, өдөр, цаг:
(МУИХЧХДТХ-ын 39.14 дэх хэсэг. Төслийг яаралтай хэлэлцэхээс бусад тохиолдолд хэлэлцүүлгээс 2 өдрийн өмнө саналаа бичгээр ирүүлнэ)

Санал хураалгасан сар, өдөр, цаг:

Зөвшөөрсөн (тоо, хувь):

58.8%

**“Монгол Улсын хөгжлийн 2026 оны төлөвлөгөө батлах тухай”
Улсын Их Хурлын тогтоолын төсөлтэй холбогдуулан гаргасан
зарчмын зөрүүтэй саналын томъёоллын хуудас**

1. Саналыг төслийн ямар зүйл, хэсэг, заалтын талаар гаргаж байгаа:

2.1. “Эрдэм боловсролтой Монгол хүн”-ийг хөгжүүлэх, тэгш, хүртээмжтэй, чанартай боловсролын нэгдсэн тогтолцоог бэхжүүлэх /заалт нэмэх/

2. Санал хураалгах болсон үндэслэл:

Багш, ажилчдын цалин хөлсний хэмжээ нэмэгдснээр боловсролын салбарын ажиллах хүчний хомсдол арилж, багш ажилчдийн хөдөлмөрийн үнэлэмжийг сайжруулж тэгш, хүртээмжтэй, чанартай боловсролын нэгдсэн тогтолцоог бэхжүүлэхэд томоохон түлхэц болно.

(Тайлбар: Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.4 дэх заалт, 39 дүгээр зүйлийн 39.18 дахь хэсэгт заасны дагуу үндэслэлээ бичээгүй бол уг зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалгахгүй)

3. САНАЛЫН ТОМЬЁОЛОЛ:

2.1.14. Багш ажилчдын цалин хөлс, нийгмийн асуудлыг тэргүүн ээлжинд сайжруулна.

Гарын үсэг: (санал гаргасан УИХ-ын гишүүн, нам, эвслийн бүлэг)

УИХ-ын гишүүн С.Эрдэнэбат

Саналыг хүлээж авсан сар, өдөр, цаг:
(МУИХЧХДТХ-ын 39.14 дэх хэсэг. Төслийг яаралтай хэлэлцэхээс бусад тохиолдолд хэлэлцүүлгээс 2 өдрийн өмнө саналаа бичгээр ирүүлнэ)

Санал хураалгасан сар, өдөр, цаг:

2025.05.20

Зөвшөөрсөн (тоо, хувь):

2351

**“Монгол Улсын хөгжлийн 2026 оны төлөвлөгөө батлах тухай”
Улсын Их Хурлын тогтоолын төсөлтэй холбогдуулан гаргасан
зарчмын зөрүүтэй саналын томьёоллын хуудас**

1. Саналыг төслийн ямар зүйл, хэсэг, заалтын талаар гаргаж байгаа:

2.2. “Эрүүл Монгол хүн”-ийг хөгжүүлэх /заалт нэмэх/

2. Санал хураалгах болсон үндэслэл:

Эрүүл Монгол хүнийг хөгжүүлэхэд “Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн асуудал” -ийг чухалчилж авч үзэх хэрэгтэй.

Эмч, эмнэлгийн ажилтны цалин хөлсийг нэмэгдүүлснээр тэдний хөдөлмөрийн үнэлэмжийг сайжруулж, тухайн салбарын ажиллах хүчний хомсдол арилж, иргэдэд хүртээжтэй, чанартай эрүүл мэндийн тусламж үйлчилгээг үзүүлэх боломж нэмэгдэнэ.

(Тайлбар: Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.4 дэх заалт, 39 дүгээр зүйлийн 39.18 дахь хэсэгт заасны дагуу үндэслэлээ бичээгүй бол уг зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалгахгүй)

3. САНАЛЫН ТОМЬЁОЛОЛ:

2.3.7. Орчны болон хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн эрсдэлийг нийгмийн түншлэгч Үйлдвэрчний эвлэл, ажил олгогчдын оролцоонд тулгуурлан бууруулна.

2.3.8. Эмч, эмнэлгийн ажилтны цалин хөлсийг жил бүр нэмэгдүүлэх

Гарын үсэг: (санал гаргасан УИХ-ын гишүүн, нам, эвслийн бүлэг)

УИХ-ын гишүүн С.Эрдэнэбат

Саналыг хүлээж авсан сар, өдөр, цаг:
(МУИХЧХДТХ-ын 39.14 дэх хэсэг. Төслийг яаралтай хэлэлцэхээс бусад тохиолдолд хэлэлцүүлгээс 2 өдрийн өмнө саналаа бичгээр ирүүлнэ)

Санал хураалгасан сар, өдөр, цаг:

2025-05-20

Зөвшөөрсөн (тоо, хувь):

79.6%

(29.4%)

**“Монгол Улсын хөгжлийн 2026 оны төлөвлөгөө батлах тухай” УИХ-ын
тогтоолын төсөлтэй холбогдуулан гаргасан зарчмын зөрүүтэй саналын
томьёоллын хуудас**

1.Саналыг төслийн ямар зүйл, хэсэг, заалтын талаар гаргаж байгаа:

1-р хавсралтын 2.2.3 дахь заалт

2.Санал хураалгах болсон үндэслэл:

Яаралтай тусламж, үйлчилгээг сайжруулж, орон нутгийн иргэдэд шаардлагатай тусламж, үйлчилгээг цаг тухайд нь хүргэснээр нас баралтыг бууруулах

(Тайлбар:Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.4 дэх заалт, 39 дүгээр зүйлийн 39.18 дахь хэсэгт заасны дагуу үндэслэлээ бичээгүй бол уг зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалгахгүй)

3.САНАЛЫН ТОМЬЁОЛОЛ:

“Монгол Улсын хөгжлийн 2026 оны төлөвлөгөө батлах тухай” УИХ-ын тогтоолын 1-р хавсралтын “2.2.3 дахь заалтын бэхжүүлж гэсний дараа **“орон нутгийн эмнэлгийн яаралтай болон түргэн тусламжийн үйлчилгээг сайжруулж,”**гэж нэмэх

Гарын үсэг: (санал гаргасан УИХ-ын гишүүн, нам, эвслийн бүлэг)

Саналыг хүлээж авсан сар, өдөр, цаг:
(МУИХЧХДТХ-ын 39.14 дэх хэсэг. Төслийг яаралтай хэлэлцэхээс бусад тохиолдолд хэлэлцүүлгээс 2 өдрийн өмнө саналаа бичгээр ирүүлнэ)

Санал хураалгасан сар, өдөр, цаг:

2025.05.20

Зөвшөөрсөн (тоо, хувь):

67.27. ✓

**“Монгол Улсын хөгжлийн 2026 оны төлөвлөгөө батлах тухай” УИХ-ын
тогтоолын төсөлтэй холбогдуулан гаргасан зарчмын зөрүүтэй саналын
томъёоллын хуудас**

1.Саналыг төслийн ямар зүйл, хэсэг, заалтын талаар гаргаж байгаа:

1-р хавсралтын 2.2.3 дахь заалт

2.Санал хураалгах болсон үндэслэл:

Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг
хэрэгжүүлэх хүрээнд

.....
(**Тайлбар:** Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн
4.1.4 дэх заалт, 39 дүгээр зүйлийн 39.18 дахь хэсэгт заасны дагуу үндэслэлээ бичээгүй бол уг
зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалгахгүй)

3.САНАЛЫН ТОМЪЁОЛОЛ:

“Монгол Улсын хөгжлийн 2026 оны төлөвлөгөө батлах тухай” УИХ-ын
тогтоолын 1-р хавсралтын “2.3.7 дахь заалтыг нэмэх

2.3.7.Гэр бүлийн цогц хөгжлийг дэмжих төвийг байгуулна.

Гарын үсэг: (санал гаргасан УИХ-ын
 гишүүн, нам, эвслийн бүлэг)

.....


Саналыг хүлээж авсан сар, өдөр, цаг:
(МУИХЧХДТХ-ын 39.14 дэх хэсэг. Төслийг
яаралтай хэлэлцэхээс бусад тохиолдолд
хэлэлцүүлгээс 2 өдрийн өмнө саналаа бичгээр
ирүүлнэ)

.....
Санал хураалгасан сар, өдөр, цаг:

2025.05.20

.....
Зөвшөөрсөн (тоо, хувь):

47.1%

**“Монгол Улсын хөгжлийн 2026 оны төлөвлөгөө батлах тухай” УИХ-ын
тогтоолын төсөлтэй холбогдуулан гаргасан зарчмын зөрүүтэй саналын
томъёоллын хуудас**

1.Саналыг төслийн ямар зүйл, хэсэг, заалтын талаар гаргаж байгаа:

1-р хавсралтын 2.2.6 дахь заалт

2.Санал хураалгах болсон үндэслэл:

Эрэгтэйчүүдийн эрүүл мэндийн чиглэлээр хэрэгжиж буй бодлого, эрхзүйн орчинг боловсронгуй болгох

.....
(Тайлбар:Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.4 дэх заалт, 39 дүгээр зүйлийн 39.18 дахь хэсэгт заасны дагуу үндэслэлээ бичээгүй бол уг зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалгахгүй)

3.САНАЛЫН ТОМЪЁОЛОЛ:

“Монгол Улсын хөгжлийн 2026 оны төлөвлөгөө батлах тухай” УИХ-ын тогтоолын 1-р хавсралтын 2.2.7 дахь заалт нэмэх

2.2.7.Эрэгтэйчүүдийн эрүүл мэндийг дэмжих, тэдэнд хүрэх тусламж үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулан, гэнэтийн осол, гадны шалтгаант нас баралтыг бууруулж, дундаж наслалтыг нэмэгдүүлнэ.

Гарын үсэг: (санал гаргасан УИХ-ын гишүүн, нам, эвслийн бүлэг)

.....


Саналыг хүлээж авсан сар, өдөр, цаг:
(МУИХЧХДТХ-ын 39.14 дэх хэсэг. Төслийг яаралтай хэлэлцэхээс бусад тохиолдолд хэлэлцүүлгээс 2 өдрийн өмнө саналаа бичгээр ирүүлнэ)

.....
Санал хураалгасан сар, өдөр, цаг:

2025-05-20

Зөвшөөрсөн (тоо, хувь):

64,7%

..... төсөлтэй холбогдуулан
гаргасан зарчмын зөрүүтэй саналын томьёоллын хуудас

1.Саналыг төслийн ямар зүйл, хэсэг, заалтын талаар гаргаж байгаа:

2.2. “Эрүүл Монгол хүн”-ийг хөгжүүлнэ.

2.2.6. Хүн амын бие бялдрын хөгжлийн түвшнийг нэмэгдүүлнэ. (Хавсралт 1)

гэснийг

Хүн амын амьдралын хэв маяг, зан үйл, орлого, боловсрол, орчин, ахуйн нөхцөл, соёл уламжлал зэрэг нийгэм, эдийн засгийн хүчин зүйлийн харгалзан, эрүүл мэндийн тэгш бус байдлыг арилгахад нөөцийг үр ашигтай хуваарилах замаар нийгмийн эрүүл мэндийн арга хэмжээг оновчтой тодорхойлж үр дүнг шалгуур үзүүлэлтээр үнэлснээр хүн амын бие бялдрын хөгжлийн түвшнийг нэмэгдүүлнэ.

гэж өөрчлөх

2.Санал хураалгах болсон үндэслэл:

“хүн амын бие бялдрын хөгжлийн түвшнийг нэмэгдүүлнэ” тунхаглалын шинжтэй томьёолол нь хүн амын эрүүл мэндийн үзүүлэлтийн суурь түвшнийг тогтоож, гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлтүүдээр үр дүнг хянах, дүгнэх, хэмжих боломжгүй агуулгыг агуулаагүй тул оновчгүй байна. (Тайлбар:Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.4 дэх заалт, 39 дүгээр зүйлийн 39.18 дахь хэсэгт заасны дагуу үндэслэлээ бичээгүй бол уг зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалгахгүй)

3.САНАЛЫН ТОМЬЁОЛОЛ:

Хүн амын амьдралын хэв маяг, зан үйл, орлого, боловсрол, орчин, ахуйн нөхцөл, соёл уламжлал зэрэг нийгэм, эдийн засгийн хүчин зүйлийн харгалзан, эрүүл мэндийн тэгш бус байдлыг арилгахад нөөцийг үр ашигтай хуваарилах замаар нийгмийн эрүүл мэндийн арга хэмжээг оновчтой тодорхойлж үр дүнг шалгуур үзүүлэлтээр үнэлснээр хүн амын бие бялдрын хөгжлийн түвшнийг нэмэгдүүлнэ.

Гарын үсэг: (санал гаргасан УИХ-ын гишүүн, нам, эвслийн бүлэг)

Саналыг хүлээж авсан сар, өдөр, цаг:
(МУИХЧХДТХ-ын 39.14 дэх хэсэг. Төслийг яаралтай хэлэлцэхээс бусад тохиолдолд хэлэлцүүлгээс 2 өдрийн өмнө саналаа бичгээр ирүүлнэ)

Санал хураалгасан сар, өдөр, цаг:

2025.05.20

Зөвшөөрсөн (тоо, хувь):

58,1%

..... төсөлтэй холбогдуулан
гаргасан зарчмын зөрүүтэй саналын томьёоллын хуудас

1.Саналыг төслийн ямар зүйл, хэсэг, заалтын талаар гаргаж байгаа:

2.2. “Эрүүл Монгол хүн”-ийг хөгжүүлнэ.

2.2.4.Эрүүл мэндийн салбарт төр, хувийн хэвшлийн түншлэлийг өргөжүүлнэ
(Хавсралт 1)

гэснийг

Төр, хувийн хэвшлийн түр ашигтай, үр дүнтэй түншлэлийг бий болгох хүрээнд эрүүл мэндийн салбарын төсөв доторх олон улсын хөтөлбөр, гадаадын зээл тусламжаар оруулсан хөрөнгө оруулалтын үр дүнг шалгуур үзүүлэлтээр үнэлдэг тогтолцоог бүрдүүлж, үр дүнг иргэдэд нээлттэй, ил тод тайлагнана.

гэж өөрчлөх

2.Санал хураалгах болсон үндэслэл:

“төр, хувийн хэвшлийн түншлэлийг өргөжүүлнэ” тунхаглалын шинжтэй үгийн цуглуулгаас зайлсхийж, аливаа түншлэл түншлэгч талуудад үр дүнтэй, үр ашигтай байх бодит зарчмын хүрээнд томьёолох нь оновчтой. Эрүүл мэндийн салбарын төсөв доторх тодорхой хувийг эзэлж байгаа олон улсын хөтөлбөр, гадаадын зээл тусламжууд нь өөр хоорондоо давхардсан, үр дүн, үр ашиг тодорхойгүй хөтөлбөрүүд хэрэгжиж, зээл, хүүгийн асуудлууд хуримтлагдаж байна. Өнөөдрийн байдлаар Эрүүл мэндийн сайдын багцад гадаадын зээл тусламжийн 845.7 тэрбум төгрөгийн 6 төсөл хөтөлбөр тусгагдсан байгаагаас ашиглаж байгаа нь зөвхөн 21% буюу 667.3 тэрбум төгрөгийн зээл ашиглагдаагүй, зээлийн хүү хуримтлагдсаар байна. Иймд олон улсын хөтөлбөр, гадаадын зээл тусламжаар эрүүл мэндийн салбарт оруулсан хөрөнгө оруулалтыг нэг бүрчлэн нягтлан шалгаж, шаардлагагүй хөрөнгө оруулалт, зээлийг түншлэл бүхий байгууллагуудтай тохиролцож, боломжтойг буцааж, зөвхөн шаардлагатай үр дүнтэй төсөв хөтөлбөрөө гүйцэтгэлтэй нь уялдуулах, шалгуур үзүүлэлтүүдийг бий болгох шаардлагатай байна. (Тайлбар:Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.4 дэх заалт, 39 дүгээр зүйлийн 39.18 дахь хэсэгт заасны дагуу үндэслэлээ бичээгүй бол уг зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалгахгүй)

3.САНАЛЫН ТОМЬЁОЛОЛ:

Төр, хувийн хэвшлийн түр ашигтай, үр дүнтэй түншлэлийг бий болгох хүрээнд эрүүл мэндийн салбарын төсөв доторх олон улсын хөтөлбөр, гадаадын зээл тусламжаар оруулсан хөрөнгө оруулалтын үр дүнг шалгуур үзүүлэлтээр үнэлдэг тогтолцоог бүрдүүлж, үр дүнг иргэдэд нээлттэй, ил тод тайлагнана.

Гарын үсэг: (санал гаргасан УИХ-ын гишүүн, нам, эвслийн бүлэг)

Саналыг хүлээж авсан сар, өдөр, цаг:
(МУИХЧХДТХ-ын 39.14 дэх хэсэг. Төслийг яаралтай хэлэлцэхээс бусад тохиолдолд хэлэлцүүлгээс 2 өдрийн өмнө саналаа бичгээр ирүүлнэ)

Санал хураалгасан сар, өдөр, цаг:

2018.05.20

Зөвшөөрсөн (тоо, хувь):

52.9%

..... төсөлтэй холбогдуулан
гаргасан зарчмын зөрүүтэй саналын томьёоллын хуудас

1. Саналыг төслийн ямар зүйл, хэсэг, заалтын талаар гаргаж байгаа:

2.2. “Эрүүл Монгол хүн”-ийг хөгжүүлнэ.

2.2.2. Эрүүл мэндийн санхүүжилтийн шинэчлэлийг хиймэл оюун ашиглан боловсронгуй болгож, эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжиж буй тусламж, үйлчилгээний давхардлыг бууруулж, үр ашгийг нэмэгдүүлнэ (Хавсралт 1)

гэснийг

Гарцад суурилсан санхүүжилтийн шинэчлэлийг бэхжүүлэх хүрээнд тусламж, үйлчилгээ худалдан авагчийн чанар, төлбөрийн хяналтыг хиймэл оюун ухааныг ашиглаж боловсронгуй болгож, эрүүл мэндийн даатгалын санхүүжилтийн үр ашгийг сангийн актуар тооцоолол дээр суурилан нэмэгдүүлнэ.

гэн өөрлөх.

2. Санал хураалгах болсон үндэслэл:

“Эрүүл мэндийн санхүүжилтийн шинэчлэлийг хиймэл оюун ашиглан боловсронгуй болгож, эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжиж буй тусламж, үйлчилгээний давхардлыг бууруулж, үр ашгийг нэмэгдүүлнэ” гэж томьёолсон нь нэгдүгээрт санхүүжилтийн өөр шинэчлэл хийгдэх тухай ойлгогдож, хоёрдугаарт санхүүжилтийн шинэчлэлд хиймэл оюун ухаан ашиглана гэдэг нь санхүүжилтийн арга хэрэгсэл, хяналт дээр хиймэл оюун ухааныг ашиглах тухай гэж ойлгогдохгүй харин санхүүжилтийн шинэчлэл дээр хиймэл оюун ухаан ашиглана гэсэн томьёолол нь санхүүжилтийн тогтолцооны хувьд авч үзэхэд оновчгүй байна. Мөн тусламж, үйлчилгээний давхардлыг бууруулах гэдэг томьёолол нь хүн амын эрүүл мэндийн эрэлт хэрэгцээг үнэлэхгүйгээр тусламж, үйлчилгээнд хязгаарлалт тавих агуулгыг агуулж байгаа бөгөөд иргэдийн тусламж, үйлчилгээний хүртээмжийг бууруулах, сэргийлж болох нас баралтыг нэмэгдүүлэх, эрүүл мэндийн хувьд эмнэл зүйн сөрөг үр дүн гарах эрсдэлүүдийг бий болгодог. Иймд эрүүл мэндийн даатгалын санхүүжилтийн үр ашгийг иргэдийн авах тусламж, үйлчилгээг хязгаарлах замаар бус сангийн актуар тооцоололд суурилж сангийн үр ашгийг нэмэгдүүлэх нь илүү оновчтой зорилго болно. (Тайлбар: Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.4 дэх заалт, 39 дүгээр зүйлийн 39.18 дахь хэсэгт заасны дагуу үндэслэлээ бичээгүй бол уг зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалгахгүй)

3. САНАЛЫН ТОМЬЁОЛОЛ:

Гарцад суурилсан санхүүжилтийн шинэчлэлийг бэхжүүлэх хүрээнд тусламж, үйлчилгээ худалдан авагчийн чанар, төлбөрийн хяналтыг хиймэл оюун ухааныг ашиглаж боловсронгуй болгож, эрүүл мэндийн даатгалын санхүүжилтийн үр ашгийг сангийн актуар тооцоолол дээр суурилан нэмэгдүүлнэ.

.....

Гарын үсэг: (санал гаргасан УИХ-ын гишүүн, нам, эвслийн бүлэг)



Саналыг хүлээж авсан сар, өдөр, цаг:
(МУИХЧХДТХ-ын 39.14 дэх хэсэг, Төслийг яаралтай хэлэлцэхээс бусад тохиолдолд хэлэлцүүлгээс 2 өдрийн өмнө саналаа бичгээр ирүүлнэ)

✓

Санал хураалгасан сар, өдөр, цаг:

2025.05.20

Зөвшөөрсөн (тоо, хувь):

52.94.

~~Сэрэл~~ Ганмаа

..... төсөлтэй холбогдуулан
гаргасан зарчмын зөрүүтэй саналын томьёоллын хуудас

1. Саналыг төслийн ямар зүйл, хэсэг, заалтын талаар гаргаж байгаа:

2.2. “Эрүүл Монгол хүн”-ийг хөгжүүлнэ.

2.2.1. Хавдар, зүрх судасны өвчлөлийн эмчилгээний шинэ технологи, туршлагыг нэвтрүүлнэ. (Хавсралт 1)

гэснийг

4 Хүн амд зонхилон тохиолдож буй зүрх судас, хавдрын өвчлөлийг эмчилгээний шинэ технологи, туршлагыг нэвтрүүлэх замаар бууруулах цогц бодлогыг хэрэгжүүлнэ. 11

2. Санал хураалгах болсон үндэслэл:

100% 800200X

“Хавдар, зүрх судасны өвчлөлийн эмчилгээний шинэ технологи, туршлагыг нэвтрүүлнэ” гэж томьёолсон нь эмчилгээний шинэ технологи, туршлага нэвтрүүлснээр яг ямар үр дүнд хүрэх гэж байгаа нь ойлгомжгүй, томьёологдоогүй, эрүүл мэндийн тогтолцооны аливаа бодлого, арга хэмжээний үр дүн бол хүн амын эрүүл мэндийг сайжруулах, тэгэхээр аливаа эмчилгээнд шинэ технологи, туршлагыг нэвтрүүлснээр тусламж, үйлчилгээний чанар, хүртээмж хэрхэн сайжирч, хүн амын эрүүл мэндэд ямар эерэг үр нөлөө гарах нь эцсийн үр дүн байдаг болохоос шинэ технологи, туршлага нэвтрүүлсэн байх нь тогтолцооны зорилго болдоггүй болохоор энэхүү томьёочлол оновчгүй байна. (Тайлбар: Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.4 дэх заалт, 39 дүгээр зүйлийн 39.18 дахь хэсэгт заасны дагуу үндэслэлээ бичээгүй бол уг зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалгахгүй)

3. САНАЛЫН ТОМЬЁОЛОЛ:

Хүн амд зонхилон тохиолдож буй зүрх судас, хавдрын өвчлөлийг эмчилгээний шинэ технологи, туршлагыг нэвтрүүлэх замаар бууруулах цогц бодлогыг хэрэгжүүлнэ.

Гарын үсэг: (санал гаргасан УИХ-ын гишүүн, нам, эвслийн бүлэг)



Саналыг хүлээж авсан сар, өдөр, цаг:

(МУИХЧХДТХ-ын 39.14 дэх хэсэг. Төслийг яаралтай хэлэлцэхээс бусад тохиолдолд хэлэлцүүлгээс 2 өдрийн өмнө саналаа бичгээр ирүүлнэ)

Санал хураалгасан сар, өдөр, цаг:

2028.05.20

Зөвшөөрсөн (тоо, хувь):

52.9%

“МОНГОЛ УЛСЫН ХӨГЖЛИЙН 2026 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ БАТЛАХ ТУХАЙ” УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛЫН
ТӨСӨЛТЭЙ ХОЛБОГДУУЛАН ЗАРЧМЫН ЗӨРҮҮТЭЙ САНАЛЫН ТОМЬЁОЛОЛ

“Монгол Улсын хөгжлийн 2026 оны төлөвлөгөө батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн Хавсралт
2-ын 1.10.1.2-д нэмэх

Төсвийн ерөнхийлөн захирагчийн үр дүн	Хөтөлбөрийн үр дүн	Бодлогын үндэслэл	НЭМЭХ САНАЛТАЙ Төсөл, Арга хэмжээ	Нийт санхүүжилтийн дүн		Үндэслэл
				Нийт /сая төг/	2026 /сая төг/	
1.10.Иргэдэд бус нутагтаа эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ авах боломж бүрдсэн байна.	1.10.1. Эрүүл мэндийн байгууллагын чадавхыг сайжруулсан байна.	1. Алсын хараа-2050 2. МУХТЖҮЧ 2021-2025 он 3. МУЗГҮАХ 2024-2028 он 4. НХТЖҮЧ 2021-2025 он	1.10.1.2 Нэгдсэн эмнэлгийн барилга, 300 ор /Улаанбаатар, Налайх дүүрэг, 2 дугаа хороо/	80,000 .0	42,000. 0	Одоогийн эрүүл мэндийн төвийн үйл ажиллагаа явуулж байгаа бүх барилга 1954-1964 онд баригдсан. Нэмж тусламж үйлчилгээ нэмэх боломжгүй болон багтаамжгүй болсон. Анхны эрүүл мэндийн хүртээмжийн төлөвлөлтөөр 5000- 8000 хүнд зориулан хийгдэж байсан бол одоо үйлчилгээ үзүүлж байгаа хүн ам 40000-45000 болж өссөн. Өсөн нэмэгдэж байгаа өвчлөл болох хавдар, бөөр шээсний зам болон гэмтлийн тасаг шинээр нээх нэн шаардлагатай. Амбулатори, уламжлалт сэргээн засах, халдварт сүрьеэгийн тасгуудын барилга хананд суулт цууралт үүссэн. Үндсэн хийцлэл тоосго болон модон учир суурийн хэсгүүдэд ялзрал мөөгөнцөр үүссэн засах арилгах боломжгүй байна. Нэгдсэн эмнэлгийн барилгын

						холболтын зураг төслийн даалгаврыг боловсруулан, дүүргийн Засаг даргаар батлуулж 2025 оны 04 дүгээр сарын 24-ний өдрийн 01/845 дугаартай албан бичгээр Бүсчилсэн хөгжлийн үндэсний хүрээлэн ТӨҮГ болон Төрийн худалдан авах ажиллагааны газарт хүргүүлсэн. 2025 оны 05 дугаар сарын 09-ний өдрийн 04/1004 дугаартай албан бичгээр зургийн даалгаврыг шинэчлэн хүргүүлсэн. Зураг төсвийн тендер зарлагдахаар хүлээгдэж байна.
--	--	--	--	--	--	--

Санал гаргасан:

Монгол Улсын Их Хурлын гишүүн



Ц.Сандаг-Очир

“Монгол Улсын хөгжлийн 2026 оны төлөвлөгөө батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн Хавсралт 2-ын 1.10.1.2-д нэмэх

Төсвийн ерөнхийлөн захирагчийн үр дүн	Хөтөлбөрийн үр дүн	Бодлогын үндэслэл	Бодлогын баримт бичигт тусгагдсан заалт	НЭМЭХ САНАЛТАЙ Төсөл, Арга хэмжээ	Нийт санхүүжилтийн дүн		Үндэслэл
					Нийт /сая төг/	2026 /сая төг/	
1.10.Иргэдэд бус нутагаа эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ авах боломж бүрдсэн байна.	1.10.1. Эрүүл мэндийн байгууллагын чадавхыг сайжруулсан байна.	1. Алсын хараа-2050 2. МУХТЖҮЧ 2021-2025 он 3. МУЗГҮАХ 2024-2028 он 4. НХТЖҮЧ 2021-2025 он	1. 9.1.1 Үе шат 1 дэх заалт. 2. 9.1.1 3. 2.3.2.1. 4. 2.11.1	1.10.1.2 Нэгдсэн эмнэлгийн барилга, 300 ор /Улаанбаатар, Налайх дүүрэг, 2 дугаа хороо/	80,000.00	42,000.00	Одоогийн эрүүл мэндийн төвийн үйл ажиллагаа явуулж байгаа бүх барилга 1954-1964 онд баригдсан. Нэмж тусламж үйлчилгээ нэмэх боломжгүй болон багтаамжгүй болсон. Анхны эрүүл мэндийн хүртээмжийн төлөвлөлтөөр 5000-8000 хүнд зориулан хийгдэж байсан бол одоо үйлчилгээ үзүүлж байгаа хүн ам 40000-45000 болж өссөн. Өсөн нэмэгдэж байгаа өвчлөл болох хавдар, бөөр шээсний зам болон гэмтлийн тасаг шинээр нээх нэн шаардлагатай. Амбулатори, уламжлалт сэргээн засах, халдварт сүрьеэгийн тасгуудын барилга хананд суулт цууралт үүссэн. Үндсэн хийцлэл тоосго болон модон учир суурийн хэсгүүдэд ялзрал мөөгөнцөр үүссэн засах арилгах боломжгүй байна. Нэгдсэн эмнэлгийн барилгын холболтын зураг төслийн даалгаврыг боловсруулан, дүүргийн Засаг даргаар батлуулж 2025 оны 04 дүгээр сарын 24-ний өдрийн 01/845 дугаартай албан бичгээр Бүсчилсэн хөгжлийн үндэсний хүрээлэн ТӨҮГ болон Төрийн худалдан авах ажиллагааны газарт хүргүүлсэн. 2025 оны 05 дугаар сарын 09-ний өдрийн 04/1004 дугаартай албан бичгээр зургийн даалгаврыг шинэчлэн хүргүүлсэн. Зураг төсвийн тендер зарлагдахаар хүлээгдэж байна.

Санал гаргасан
Монгол Улсын Их Хурлын гишүүн

Ц.Сандаг-Очир

“МОНГОЛ УЛСЫН ХӨГЖЛИЙН 2026 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ БАТЛАХ ТУХАЙ” МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛЫН
ТӨСЛИЙН 2 ДУГААР ХАВСРАЛТЫН ТАЛААРХ ЗАРЧМЫН ЗӨРҮҮТЭЙ САНАЛЫН ТОМЬЁОЛЛЫН ХУУДАС

Загвар-1

Санамж: Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.10.2 дахь заалтад заасны дагуу нэг жилийн хугацаанд хэрэгжүүлэх хөгжлийн төлөвлөлтийн баримт бичиг нь “санхүүжилтийн эх үүсвэрийг тодорхойлсон, шаардлагатай хөрөнгө оруулалтын хэмжээг урьдчилан тооцсон, хариуцах эзэнтэй, техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөв нь батлагдсан, тухайн жилд хэрэгжүүлэх шаардлагатай төсөл, арга хэмжээг эрэмбэлсэн байх” шаардлагыг хангасан байна.

Төсөл, арга хэмжээ өөрчлөх /нэмэх/ санал

Төсвийн ерөнхийлөн захирагчийн үр дүн	Хөтөл- бөрийн үр дүн	Бодлогын үндэслэл	Төсөл, арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Хэмжих нэгж	Үр дүнгийн үзүүлэлт		Нийт санхүүжил- тийн дүн сая.төг	Тухайн жилд шаардагдах санхүүжилт сая.төг	Санхүүжил- тийн эх үүсвэрийн ангилал	Үндсэн хариуцагч
						Суурь түвшин	Зорилтот түвшин				
2.1. Халдварт болон халдварт бус шалтгаант нас баралтыг бууруулсан байна	2.1.1.Эмнэлтийн тусламж үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлсэн байна	АХ-2.2.20 ЗГҮАХ-2.3.1.4 2.3.2.2	2.1.1.8. Баянзүрх дүүргийн нэгдсэн эмнэлгийн барилга худалдан авах	Барилга худалдан авах	Хувь	-	100	40,000,000.00	10,000,000.00	Орон нутгын төсөв	Нийслэлийн Засаг даргын тамгын газар
2.1. Халдварт болон халдварт бус шалтгаант нас баралтыг бууруулсан байна	2.1.3. Элэг бүтэн Монгол хөтөлбөрийг үргэлжлүүлэх	АХ-2.2.20 ЗГҮАХ-2.3.1.4 2.3.2.2	2.1.3.1. Б, Д вирустай иргэдийг эмчилгээг үргэлжлүүлэх	Вирусын эсрэг эмчилгээ	Хувь	-	1	20,000,000.00	20,000,000.00	Улсын төсөв	Эрүүл мэндийн яам
2.1. Халдварт болон халдварт бус шалтгаант нас баралтыг бууруулсан байна	2.1.4. Эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд орчин үеийн техник технологийг нэвтрүүлнэ	АХ-2.2.20 ЗГҮАХ-2.3.1.4 2.3.2.2	2.1.4.1.Робот мэс заслыг Монгол улсад нэвтрүүлэх, тус мэс заслын аргаар хагалгаа хийж эхлэх	Хагалгаа хийсэн тоо	Тоо	-	50	5,000,000.00	5,000,000.00	Улсын төсөв	Эрүүл мэндийн яам

Санал гаргасан: Улсын Их Хурлын гишүүн /Ж.ЧИНБҮРЭН/ 2025 оны 05 дугаар сарын 19-ний өдөр

2025.05.19-ны 15:47м.

**“МОНГОЛ УЛСЫН ХӨГЖЛИЙН 2026 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ БАТЛАХ
ТУХАЙ” МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛЫН
ТӨСЛИЙН 1 ДҮГЭЭР ХАВСРАЛТТАЙ холбогдуулан
гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллын хуудас**

1. Саналыг төслийн ямар зүйл, хэсэг, заалтын талаар гаргаж байгаа:

- Хоёрдугаар зүйлийн 2.2 дах хэсэгт 2.2.7 дах заалт нэмж оруулах,

2. Санал хураалгах болсон үндэслэл:

- Монгол Улсын Засгийн Газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.3.1, 2.1.4-т заасан зорилтуудын хэрэгжилтийг эрчимжүүлэх,
- Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан Эрүүл Монгол хүн-Үндэсний хөдөлгөөний хүрээнд бусад салбар дамнасан бодлогын уялдааг хангах, стандартыг шинэчлэх,
- Эрүүл мэндийн тухай хуулийн 6.1.1-д заасныг хэрэгжүүлэх хэрэгцээ шаардлага байна,
- Одоо хэрэгжиж байгаа олон хөтөлбөрүүдийн уялдааг хангах, нэгдсэн бодлоготой болгох,

(Тайлбар: Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.4 дэх заалт, 39 дүгээр зүйлийн 39.18 дахь хэсэгт заасны дагуу үндэслэлээ бичээгүй бол уг зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалгахгүй)

3. САНАЛЫН ТОМЪЁОЛОЛ:

- ~~2.2.7. Нийтийн эрүүл мэндийн Үндэсний хөтөлбөр (2026-2040) батлах,~~

2.2.7. Нийтийн эрүүл мэндийн ~~хөтөлбөр~~ хөгжлийн бодлого (2026-2040) батлах.

Гарын үсэг: (санал гаргасан УИХ-ын гишүүн, нам, эвслийн бүлэг)

Саналыг хүлээж авсан сар, өдөр, цаг:

(МУИХЧХДТХ-ын 39.14 дэх хэсэг. Төслийг яаралтай хэлэлцэхээс бусад тохиолдолд хэлэлцүүлгээс 2 өдрийн өмнө саналаа бичгээр ирүүлнэ)

Санал хураалгасан сар, өдөр, цаг:

2025.05.20.

Зөвшөөрсөн (тоо, хувь):

29.47.

**“МОНГОЛ УЛСЫН ХӨГЖЛИЙН 2026 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ БАТЛАХ
ТУХАЙ” МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛЫН
ТӨСЛИЙН 1 ДҮГЭЭР ХАВСРАЛТТАЙ холбогдуулан
гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллын хуудас**

1. Саналыг төслийн ямар зүйл, хэсэг, заалтын талаар гаргаж байгаа:

- Хоёрдугаар зүйлийн 2.3 дах хэсгийн 2.3.3 дах заалтыг өөрчлөн найруулах,

2. Санал хураалгах болсон үндэслэл:


- Монгол Улсын Засгийн Газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.1.1.5, 2.1.1.6, 2.1.1.7-д заасан зорилтуудыг хэрэгжүүлэх,
- Хүүхэд хамгааллын тухай хуулийг олон нийтэд таниулах, хуулийн хэрэгжилтийг хангах,

(Тайлбар: Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.4 дэх заалт, 39 дүгээр зүйлийн 39.18 дахь хэсэгт заасны дагуу үндэслэлээ бичээгүй бол уг зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалгахгүй)

3. САНАЛЫН ТОМЪЁОЛОЛ:

- 2.3.3. Хүүхэд хамгааллын кейс менежмент, нийгмийн ажлын мэргэжлийн удирдлагыг хөгжүүлж, төрийн бүх албан хаагчдыг хүүхэд хамгааллын болон хүний эрхийн цахим сургалтад хамруулж, хүүхэд хамгааллын үйлчилгээг хүүхэд бүрд хүргэнэ.

Гарын үсэг: (санал гаргасан УИХ-ын гишүүн, нам, эвслийн бүлэг)

.....


Саналыг хүлээж авсан сар, өдөр, цаг:
(МУИХЧХДТХ-ын 39.14 дэх хэсэг. Төслийг яаралтай хэлэлцэхээс бусад тохиолдолд хэлэлцүүлгээс 2 өдрийн өмнө саналаа бичгээр ирүүлнэ)

.....
Санал хураалгасан сар, өдөр, цаг:

.....
2025. 08. 20
Зөвшөөрсөн (тоо, хувь):
58,8%
.....

**“Монгол Улсын хөгжлийн 2026 оны төлөвлөгөө батлах тухай” УИХ-ын
тогтоолын төсөлтэй холбогдуулан гаргасан зарчмын зөрүүтэй саналын
томьёоллын хуудас**

1. Саналыг төслийн ямар зүйл, хэсэг, заалтын талаар гаргаж байгаа:

1-р хавсралтын 2.2.8 дахь заалт

2. Санал хураалгах болсон үндэслэл:

Нийгмийн эрүүл мэндийн тухай хуулийг хэрэгжүүлэх хүрээнд


.....
(**Тайлбар:** Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.4 дэх заалт, 39 дүгээр зүйлийн 39.18 дахь хэсэгт заасны дагуу үндэслэлээ бичээгүй бол уг зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалгахгүй)

3. САНАЛЫН ТОМЬЁОЛОЛ:

“Монгол Улсын хөгжлийн 2026 оны төлөвлөгөө батлах тухай” УИХ-ын тогтоолын 1-р хавсралтад 2.3.8 дахь заалтыг нэмэх


2.3.8. Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний нэгдсэн тогтолцоо бүрдүүлэх зорилгоор орон нутагт Нийгмийн эрүүл мэндийн төв байгуулна.

Гарын үсэг: (санал гаргасан УИХ-ын гишүүн, нам, эвслийн бүлэг)



Саналыг хүлээж авсан сар, өдөр, цаг:
(МУИХЧХДТХ-ын 39.14 дэх хэсэг. Төслийг яаралтай хэлэлцэхээс бусад тохиолдолд хэлэлцүүлгээс 2 өдрийн өмнө саналаа бичгээр ирүүлнэ)

.....
Санал хураалгасан сар, өдөр, цаг:



.....
Зөвшөөрсөн (тоо, хувь):

.....